



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС:

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа

АГУУЛГА

1.БНХАУ-ЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	2
Хятад Улс дахь авлигын нөхцөл байдал:	2
Улс төрийн орчин:	3
Хууль эрх зүйн орчин:	4
Шүгэл үлээгчийн хамгаалалт:.....	5
Авлигатай тэмцэх стратеги:.....	5
Авлигатай тэмцэх байгууллага:.....	5
2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР СҮҮЛИЙН САРУУДАД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	7

1.БНХАУ-ЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хятад Улс дахь авлигын нөхцөл байдал: Трансперэнси Интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн судалгаагаар тус улс 2013 онд дэлхийн 178 улс орноос 80 дугаар байрт эрэмбэлэгдэж байсан юм. Хятад улс дахь авлигын түгээмэл хэлбэр нь хээл хахууль, хөрөнгө завших, хууль бусаар гэрээ байгуулах, танил тал, хамаатнаараа дамжуулан асуудлыг шийдвэрлэх зэрэг бөгөөд хувийн хэвшил, хууль тогтоох байгууллага, төрийн албан хаагч, цагдаагийн байгууллага авлига ихтэй гэж үздэг байна.

Коммунист намын албан тушаалтнууд болон Хятадын иргэдийн дунд явуулсан төсөөллийн судалгаануудын дүнгээс харахад тус улсад анхаарал татсан асуудлын нэг бол “авлига” юм. Намын төв сургуулийн судлаачдын явуулсан 1999-2004 судалгааны дүнгээр тус улсын нийгэм дэх хамгийн ноцтой асуудлын нэг, хоёрдугаар байрт авлигыг нэрлэсээр ирсэн байдаг. Үүнтэй адилаар 2006 оны сүүлээр Төрийн зөвлөлийн дэргэдэх Судалгаа шинжилгээний төвөөс төрийн оролцоогүй аж ахуйн нэгжүүдийн 87 хувь буюу 4586 бизнес эрхлэгчийг хамруулсан судалгаа явуулсан юм. Уг судалгаагаар орон нутгийн захиргааны байгууллагын шударга байдлыг үнэлүүлсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 25 хувь нь орон нутгийн захиргааны байгууллагын шударга байдлыг “муу” 12 хувь нь “маш муу” гэж үнэлсэн байдаг.

Хүснэгт 1. Хятад, Монгол Улсын зарим үзүүлэлтийн харьцуулалт, судалгааны дүн, харьцуулснаар

Д/д	Үзүүлэлт	Хятад	Монгол
1.	ТИ-Авлигын төсөөллийн индекс 2013 онд - эрэмбэ (177 улсаас) - оноо (100 онооноос)	80-р байр 40	83-р байр 38
2.	ТИ-Дэлхийн авлигын хэмжүүр судалгаа 2011 онд - Авлигатай салбарын талаарх төсөөлөл	-Хувийн хэвшил, -Хууль тогтоох байгууллага, -Төрийн албан хаагч, -Цагдаа	-Хууль тогтоох байгууллага, - Улс төрийн нам, - Шүүх засаглал -Боловсролын систем
3.	Дэлхийн шударга ёсны индекс, 2013 онд - Эрэмбэ (99 улсаас) - Оноо (1 хүртэл)	76 0.45	51 0.51
4.	Хүний хөгжлийн индекс, 2013 онд - Эрэмбэ (193 улсаас) - Оноо (1-хүртэл)	91 0.719	103 0.698
5.	Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам. доллар	6 807	4 056
6.	ДНБ, оны үнээр	9 240.0 их наяд ам. доллар	11.5 тэрбум ам. доллар
7.	Хүн амын тоо, сая хүн	1 367.3	2.9

Хятадын Ардын прокурорын Ерөнхий прокурор Цао Цзяньмин /Cao Jianming/ 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Ардын их хурлын Байнгын хорооны хуралдаанд авлига, хээл хахууль болон хөрөнгө завших хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны талаар танилцуулсан юм. Тус танилцуулгад дурдсанаар 2013 онд прокурорын байгууллага 198781 хүн оролцсон 151350 авлига, хээл хахууль болон хөрөнгө завшсан хэргийг мөрдөн шалгасан байна.

Нийт авлигын хэрэгт холбогдон шалгагдсан хүмүүсийн 167514-д нь прокуророос яллах шийдвэр дүгнэлт үйлдсэн бөгөөд 148931 хүнийг буруутай болохыг шүүхээс тогтоогдсон байна.

Дээр дурдсан авлигын гэмт хэргийг шалгаснаар нийт 6.06 тэрбум ам. доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг нөхөн төлүүлсэн байна.

Хүснэгт 2. Шалгагдсан авлигын гэмт хэргийн талаарх мэдээлэл, 2013 онд

Д/д	Үзүүлэлт	Хятад	Монгол ¹
1.	Шалгасан авлигын хэрэг	151 350	187
2.	Хэрэгт холбогдуулан шалгасан хүн	198 781	400
3.	Яллах шийдвэр дүгнэлтээр шүүхэд шилжүүлсэн хүн	167 514	33
4.	Шүүхээс буруутай болох нь тогтоогдсон хүн	148 931	26 ²
5.	Нөхөн төлүүлсэн хөрөнгө	6.06 тэрбум ам. доллар	6.3 тэрбум төгрөг

Цао Цзяньминийн онцлон тэмдэглэсэнээр “авлигын талаарх мэдээлэл хүлээж авах суваг нэмэгдэж байгаа ч прокурорын байгууллагын хууль сахиулах чадавх, ажиллах арга барил, механизмыг сайжруулах хэрэгцээтэй байгаа” аж. Ийнхүү Ардын прокурорын Ерөнхий прокурор Ардын их хурлын Байнгын хороонд авлигын асуудлаар танилцуулга хийсэн явдал нь 1989 оноос хойш анхных болсон юм.

Үүний дараа 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Хятадын коммунист намын Сахилга, хяналтын төв хороо болон Хяналт шалгалтын яамнаас танилцуулга гаргасан юм. Уг танилцуулгад дурдсанаар 2013 онд улсын хэмжээний сахилгын хяналт болон хяналт, шалгалтын байгууллагуудад нийтдээ авлига, албан тушаалтай холбоотой 1950374 гомдол мэдээлэл ирснээс 172532-т нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 182038 хүн (үүний дотор өндөр албан тушаал хашдаг 31 хүн)-д хариуцлага хүлээлгэсэн гэжээ.

Улс төрийн орчин: Тус улсын эдийн засгийн огцом өсөлт нь төрийн албан хаагчдыг авлигын хэрэгт холбогдох, хууль бусаар баяжих боломжийг нэмэгдүүлсэн. Энэ байдал нь Хятадын удирдлагын хүрээнд томоохон сорилтыг бий болгосон бөгөөд эдийн засгийн өсөлтөө хадгалах, авлигыг хязгаарлах шаардлага зүй ёсоор тавигдах

¹ Мөрдөн шалгах хэлтсийн мэдээлэл

² Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн 43 эрүүгийн хэрэгт 163 хүнийг яллагдагчаар татсан бөгөөд шүүхээр шийдвэрлэсэн 11 хэргийн 33 шүүгдэгчээс 26 шүүгдэгчийг шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон.

болсон юм. Энэ ч хүрээнд Хятадын дарга, ноён Си Зиньпин өндөр болон доогуур түвшний албан хаагчдын авлигатай тууштай тэмцэхээ 2013 оны 4 дүгээр сард амласныг барууны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дамжуулж байсан юм.

Мөн 2014 оны 3 дугаар сард “Bloomberg” “Хятад улсад 2013 онд нийт 182000 албан тушаалтныг авлига, албан тушаалын хэрэг холбогдуулан шийтгэсэн байна. Эдгээр албан тушаалтнуудын дунд

- Чунцин муж дахь Коммунист намын дарга асан Бо Силай /Bo Xilai/,
- Тээврийн товчооны дарга асан Зан Шуган /Zhang Shuguang/,
- Төмөр замын сайд асан Ли Зижин /Liu Zhijun/,
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга асан Ли Тинан /Liu Tienan/

зэрэг өндөр албан тушаалтай хүмүүс багтсан байдаг.” гэж мэдээлсэн.

Харин 2014 онд Си Зиньпины удирдаж буй авлигын эсрэг үйл ажиллагаа улам бүр өргөжин намын улс төрийн товчооны гишүүдийн бичигдээгүй хууль буюу халдашгүй байдалд нөлөөлөх болсон юм. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын дарга асан Зой Юнкан /Zhou Yongkang/, Ардын чөлөөлөх армийн генерал Гу Жунсан /Gu Junshan/ нарын зэрэг хүмүүсийг авлигын хэрэг холбогдуулан шалгаж эхлээд байгаа юм.

Хууль эрх зүйн орчин: БНХАУ-ын Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийг төрийн байгууллага дахь идэвхтэй, идэвхгүй авлига; бусдыг сүрдүүлэн мөнгө авах; мөнгө угаах; төрийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг олон төрлөөр тодорхойлсон байдаг. Мөн төрийн албан хаагчдад санал болгосон хээл хахуулийн хэмжээ 10000 юаниас их бол эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг байна. Тус улсын эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт зааснаар:

- 10000-200000 юанийн хахуулийн гэмт хэрэгт 5 хүртэлх жилийн хорих ял
- 200000-1000000 юанийн “ноцтой” хахуулийн гэмт хэрэгт 5-10 жилийн хорих ял
- 1000000 юаниас дээш болон эдийн засагт шууд хэмжээгээр 5000000 юаниас дээш хэмжээний хохирол учруулсан “онц ноцтой” хахуулийн гэмт хэрэгт 10-аас дээш жилийн хорих ял
- Үндэсний ашиг сонирхлыг зөрчсөн (эдийн засагт шууд хэмжээгээрээ 1000000 юаниас илүү хохирол учруулсан) хахуулийн хэрэгт 5-10 жилийн хорих ялаар тус тус шийтгэдэг.

Эрүүл мэнд, аюулгүй байдлын салбарын авлигын асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Тус улсын эрүүгийн хуульд мөн гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын ажилтны авлигын хэргийг шалгах заалт тусгагдсан байдаг ч 2014 оны 4 дүгээр сарын байдлаар гадаадын төрийн албан хаагчтай холбоотой авлигын гэмт хэргийн мөрдөн байцаалт явуулсан гэсэн мэдээлэл байхгүй юм.

БНХАУ нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид 2003 онд нэгдэн, 2006 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан юм. Тус улс хувийн салбар дахь авлига, хувийн компаниуд болон тэдгээрийн удирдлагууд хээл хахууль, бэлэг өгөх замаар хууль бусаар давуу байдал олж авахыг хориглосон “Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль”-ийг 1993 онд /Anti Unfair Competition Law/ баталсан байдаг. 2003 онд Санхүүгийн

институцийн мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжийг баталсан нь тус улсын санхүүгийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөөлсөн юм.

Шүгэл үлээгчийн хамгаалалт: Хятадын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар тус улс шүгэл үлээгчийг хамгаалах үйл ажиллагааг дэмждэг юм. Тус хуульд зааснаар хууль бус буюу зөвшөөрөлгүй үйл ажиллагааг иргэд мэдээлэх эрхтэй ажээ. Дэлхийн шударга ёсны тайлан /Global Integrity Report/-д дурдсанаар шүгэл үлээсэн төрийн албан хаагчийг холбогдох хууль тогтоомжоор хамгаалсан байдаг аж. Үүнээс гадна Хятадын Ардын дээд прокурорын газар авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл авах 24 цагийн утас болон вэбсайтыг ажиллуулдаг. Мөн Сахилга, хяналтын төв хороо болон Хяналт шалгалтын яам хамтран иргэдийн гомдол мэдээллийг хүлээн авах “12388.gov.cn” вэб хуудсыг нээн ажиллуулж байна. “Freedomhouse” байгууллагын үзэж байгаагаар блогчид болон сэтгүүлчдийн илчилснээр маш олон тооны доогуур болон дунд түвшний албан тушаалтнууд шийтгэгдээд байгаа аж. Гэсэн хэдий ч тус улсын засгийн газраас иргэдээ өгч байгаа мэдээллээ шууд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр илчлэхээс илүүтэйгээр засгийн газрын албан ёсны сүлжээгээр дамжуулан илчлэхийг хүссээр байгаа юм.

Авлигатай тэмцэх стратеги: 2013 онд БНХАУ “Авлигатай тэмцэх 2 дахь таван жилийн төлөвлөгөөг /([建立健全惩治和预防腐败体系2013-2017年工作规划](#))/ гаргасан юм. Тус улсын дарга Си Зиньпин авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүн болон Авлигатай тэмцэх 2 дахь таван жилийн төлөвлөгөө 2013-2014”-ний дагуу 2013 онд үндэсний хэмжээнд өндөр болон доогуур түвшний 182000 албан тушаалтанд авлига, албан тушаалын хэргээр шийтгэл ногдуулсан байна.

Мөн үүнээс гадна Хятадын Коммунист намын гишүүний ёс зүйн дүрэм байдаг бөгөөд уг дүрэмд албан тушаалтнуудын авлигыг хязгаарлах зорилготой 52 дүрэм нэгдсэн аж.

Сүүлийн жилүүдэд тус улс төрийн албан хаагч болон өндөр албан тушаалтнуудын оролцсон уулзалт, зөвлөгөөн, хурал, тэмдэглэлт баяр, ёслолыг тансаг байдлаар хэтрүүлэн тэмдэглэх, албаны унаа ашиглах зэрэг авлигын хэлбэрийг бууруулах талаар онцгой анхаарч ажиллаж байгаа юм. “Wall Street Journal”-ын 2012 оны 1 дүгээр сарын дугаарт БНХАУ ач холбогдол багатай тэмдэглэлт баяр, семинар, уулзалтыг бууруулснаар 193 сая ам. долларыг хэмнэсэн гэж мэдээлж байсан юм. Үүнээс гадна тус улсад 1000 юаниас илүү үнэ өртөг бүхий бэлгийн карт өгөхийг хориглосон байгаа ч тус улсын зарим мэдээллийн хэрэгслийн үзэж байгаагаар соёлын хүчин зүйлээс үүдэлтэйгээр бэлгийн картын талаарх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа ажээ.

Авлигатай тэмцэх байгууллага:

- **Сахилга, хяналтын төв хороо:** Хятадын Коммунист намын өндөр албан тушаалтнуудын дунд шударга байдлыг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага бол Коммунист намын **Сахилга, хяналтын төв хороо** /Central Committee for Discipline Inspection/ юм. Сахилга, хяналтын төв хороо нь Коммунист намын гишүүдээс гадна тус улсын Засгийн газрын хэмжээний авлигын хэргийг хянах, шалгах үйл ажиллагааг голлон явуулдаг байна. Сахилга, хяналтын төв хорооноос өндөр албан тушаалтнуудын эсрэг дотоод мөрдөн байцаалт явуулахад тус улсын төрийн

байгууллагын шаталсан бүтцийн дагуу, удирдах албан тушаалтнаа мөрдөх нь ихээхэн хүндрэлтэй байдаг юм. Анх 1927 онд Хятадын Коммунист намын Төв хянан шалгах хороо нэртэй байгуулагдсан бөгөөд 1949 онд одоогийн нэрээрээ Сахилга, хяналтын төв хороо болж өөрчлөгдсөн. Сахилга, хяналтын төв хорооноос сүүлийн үед хэрэгжүүлж буй томоохон ажлын нэг бол **хөрөнгө мэдүүлсэн өндөр албан тушаалтнуудыг санамсаргүй байдлаар сонгон шалгах үйл ажиллагаа юм.** Тус байгууллагын вэб хуудсанд иргэд гомдол, мэдээлэл өгөх эсвэл авлигын хэргийн мөрдөн байцаалттай холбоотой мэдээлэл авах дэд хэсгүүдийг нээснийг 2013 оны 9 дүгээр сард Синхуа агентлагийн мэдээлсэн.

- **Хяналт шалгалтын яам:** Авлигатай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өөр нэг байгууллага бол БНХАУ-ын Төрийн зөвлөлд харьяалагддаг **Хяналт шалгалтын яам** /Ministry of Supervision/ юм. Хяналт шалгалтын яам нь төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, захиргааны үр ашигтай байдлыг өргөжүүлэх, цэвэр, цэгц шударга төрийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, төрийн албаны сахилга батыг нэмэгдүүлэх, засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах зэрэг асуудалд мэргэжлийн байгууллагын зүгээс хяналт тавих, шалгалт зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм. Хяналт шалгалтын яам нь Төрийн зөвлөлийн удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хуульд заасны дагуу тус байгууллагын чиг үүргээ гүйцэтгэх нь аливаа төрийн байгууллага, хувь хүний нөлөөллөөс хараат бус юм.

- **Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний товчоо:** Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний товчоо³ /National Bureau of Corruption Prevention/ нь Төрийн зөвлөлийн Хяналт шалгалтын яамны удирдлагад үйл ажиллагаагаа явуулдаг агентлаг юм. Гэхдээ тус агентлаг авлигын хэргийн мөрдөн шалгах бус үндэсний хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулан явуулах үндсэн үүрэгтэй.

- **Авлигын талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах /омбудсман/ байгууллага:** Ардын дээд шүүх, Ардын дээд прокурор, Ард түмний конгресс, Гомдлын газар, Үндэсний аудитын газар, Хяналт шалгалтын яам зэрэг байгууллагууд тус улсад омбудсманы үүргийг гүйцэтгэдэг. 2011 он Дэлхийн шударга ёсны тайланд дээрх байгууллагуудын улс төрөөс хараат байдлыг “дунд зэрэг” гэж үнэлсэн байдаг.

Эх сурвалж:

- <http://www.business-anti-corruption.com/country-profiles/east-asia-the-pacific/china/initiatives/public-anti-corruption-initiatives.aspx>
- http://www.iaaca.org/AntiCorruptionAuthorities/ByCountriesandRegions/C/China/jigo_u/201202/t20120209_801305.shtml
- <http://politics.people.com.cn/n/2013/1225/c1001-23946537.html>
- <http://en.chinacourt.org/public/detail.php?id=3306>
- <http://www.anticorruptionblog.com/>
- <http://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD>
- <http://hdr.undp.org/en/content/human-development-index-hdi>
- http://worldjusticeproject.org/sites/default/files/files/country_profiles.pdf

³ вэб хуудас: <http://www.nbc.gov.cn>

2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР СҮҮЛИЙН САРУУДАД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2014 оны 8 дугаар сард	
1. Хууль тогтоомжийн хүрээнд	-
2. Шинэ болон шинэчлэн боловсруулахаар зорьж буй хууль тогтоомж	-
3. Засгийн газраас авлигын гэмт хэрэгтэй тэмцэхээр хэрэгжүүлж буй томоохон үйл ажиллагаа	<p>(1) Барилгын төсөл зэрэг томоохон үйл ажиллагаанаас 3.49 сая ам. долларын хээл хахууль авсан хэргээр Хунан /Hunan/ мужийн тээврийн газрын орлогч дарга асан Зой Хэпинг /Zou Heping/-д тус мужийн шүүхээс бүх насаар нь хорих шийдвэр гаргасныг 8 дугаар сарын 8-нд мэдээллээ.</p> <p>(2) Хээл хахууль авсан, хөрөнгө завшсан хэргээр Наньян хотын шүүхээс Хэнань мужийн Наньян хотын Үр тарианы товчооны дарга асан Цао Пушэн /Cao Pusheng/-д 2014 оны 8 дугаар сарын 8-нд 19 жилийн хорих ял ногдуулав. Мөн түүний 164000 ам. доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг хурааж авав.</p> <p>(3) Хэнань мужийн улс төрийн товчооны гишүүн, дэд дарга Ванг Тэиниу /Wang Teiniu/-д 2014 оны 8 дугаар сарын 10-нд тус мужийн ардын шүүхээс 11 жилийн хорих ял ногдуулж, 16277 ам.долларын өртөг бүхий хөрөнгийг нь хурааж авав.</p> <p>(4) Хууль бусаар баяжсан, хээл хахууль авсан, хөрөнгө завшсан хэргээр Хөх хотын төмөр замын шүүхээс Өвөр Монголын Автономит мужийн Ордос хотын Ардын хурлын дэд дарга асан Эрл Дун Кан /Earl Dun Cang/-д бүх насаар нь хорих ялаар шийтгэж, түүний бүх хөрөнгийг нь хураах шийдвэр гаргажээ.</p> <p>(5) Шаньси мужийн Тайюан хотын Төмөр замын удирдах газрын дэд дарга асан Вэн Кинглианд /Wen Qingliang/-д Бээжин хотын Хяналтын 2 дугаар шүүхээс нүүрсний 6 компаниас 3.25 сая ам. долларын хээл хахууль авсан хэрэгт буруутган хоёр жилийн дараа цаазаар авах ял ногдуулж, бүх хөрөнгийг нь хураан авав.</p>
Бусад арга хэмжээ:	-
2014 оны 7 дугаар сард	
1. Хууль тогтоомжийн хүрээнд	
Улсын түвшинд	<p>(1) 2014 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Хятадын коммунист намын Төв газар болон Төрийн зөвлөлийн Төв хороо хамтран төрийн албан хаагчид засгийн газрын машиныг хэрэглэхтэй холбоотой хамтарсан удирдамж гаргав. Удирдамжид заасны дагуу дэд сайдын түвшнээс доогуур түвшний албан хаагч албаны унаагаар хангагдахыг хориглосон юм. Энд тусгай зориулалтын болон түргэний тэрэг хамаарахгүй аж. Энэ шинэчлэлийг 2014 оны эцэс гэхэд төрийн төв байгууллагуудад бүрэн нэвтрүүлэх ба үүний дараа орон нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх аж.</p>

	<p>(2) Хятадын Коммунист намын Сахилгын хяналтын төв хороо, Коммунист намын төв хорооны Зохион байгуулалтын газар, Төрийн байгууллагын шинэчлэлийн улсын хороо, Хяналт шалгалтын яам, Хүний нөөц, нийгмийн хамгааллын яам, Үндэсний аудитын газар, Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо хамтран 2014 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газар, намын өндөр албан тушаалтнууд болон Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн удирдлагын эдийн засгийн хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх "Хэрэгжилтийн журам"-ыг батлав. Энэхүү журмын зорилго нь төрийн албан хаагчид болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн удирдлагын үйл ажиллагаан дахь хяналтыг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох зорилготой юм. Журамд зааснаар томоохон албан тушаал хашиж байгаа дээрх этгээдүүдийг албан үүргийн хэрэгжилтэд албан тушаал хаших хугацаанд нь нэгээс доошгүй удаа аудитын хяналт шалгалтыг хийж, үнэлгээ өгч байхаар болжээ.</p>
<p>2. Шинэ болон шинэчлэн боловсруулахаар зорьж буй хууль тогтоомж</p>	<p>-</p>
<p>3. Засгийн газраас авлигын гэмт хэрэгтэй тэмцэхээр хэрэгжүүлж буй томоохон үйл ажиллагаа</p>	<p>(1) Хайнан мужийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын газрын дарга асан Ван Юингфү /Wang Yingfu/-д хээл хахууль авсан хэрэгт буруутган, Хяналтын шатны шүүхээс 12 жилийн хорих ял ногдуулсан байна. Ван Юингфү уг шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн, давж заалдахаа мэдэгдсэн юм.</p> <p>(2) Гансу муж дахь Хятадын ардын зөвлөлийн бага хурлын дарга асан Янг Лин /Yang Lin/-г хээл хахууль авсан зэрэг хэрэгт буруутган шүүхээс 7 дугаар сарын 3-ны өдөр бүх насаар нь хорих ял ногдуулан, хөрөнгийг нь хураах шийдвэр гаргасан байна.</p> <p>(3) Зянсу мужийн Наньтун хотын газрын албаны дэд дарга Рен Гонгли /Ren Gongli/-г хээл хахууль авсан хэрэгт буруутган тус хотын шүүхээс 7 жил хорих ял ногдуулж, хувийн 64831 ам. долларын өртөг бүхий хөрөнгийг нь хураах шийдвэр гаргасан байна. Тэрээр үл хөдлөх хөрөнгийн зуучлагч компаниас болон хувь хүнээс 22 удаагийн үйлдлээр хээл хахууль авсан нь тогтоогдсон юм.</p> <p>(4) 2014 оны 7 дугаар сарын 17-ны өдөр Өвөр Монголын Хөдөлмөрийн газрын дарга, Хятадын коммунист намын Байнгын хорооны гишүүн асан Ван Суй /Wang Suyi/-г хээл хахууль авсан хэрэгт буруутган Бээжингийн Ардын 1 дүгээр шүүхээс бүх насаар нь хорих ял ногдуулж, бүх хөрөнгийг нь хураан авсан байна.</p> <p>(5) Төрийн өмчит гурван компани болох "Shenzhen Kehuitong Investment Holding", "Shenzhen Shennan Petroleum", "Shenzhen Guangju Energy"-ийн захирал асан Ван Жианбин /Wang Jianbin/-ийг хээл хахууль авсан хэрэгт буруутган Шэньжэнь хотын шүүхээс 15 жилийн хорих ял ногдуулахын зэрэгцээ, хувийн 16000 ам. долларын хөрөнгийг нь хураах шийдвэр гаргасан байна.</p> <p>(6) 2014 оны 7 дугаар сарын 29-ний өдөр Коммунист намын Сахилгын хяналтын төв хороо болон Хяналт шалгалтын яамны цахим хуудсанд тус улс дахь хамгийн нөлөө бүхий этгээдүүдийн нэг болох Хятадын Коммунист намын Улс төрийн товчооны гишүүн асан, Хятадын аюулгүй байдлын сайд асан Зой Юнканий эсрэг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж байгаагаа албан ёсоор</p>

	мэдэгдсэн юм. Түүнийг сахилгын хэд хэдэн зөрчил гаргасан хэмээн үзэж байгаа юм.
Бусад арга хэмжээ:	-
2014 оны 6 дугаар сард	
1. Хууль тогтоомжийн хүрээнд	-
2. Шинэ болон шинэчлэн боловсруулахаар зорьж буй хууль тогтоомж	-
3. Засгийн газраас авлигын гэмт хэрэгтэй тэмцэхээр хэрэгжүүлж буй томоохон үйл ажиллагаа	<p>(1) Хятадын коммунист намын Сахилгын хяналтын төв хороо болон Хяналт шалгалтын яамны албан ёсны цахим хуудсанд 2014 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Коммунист намын Жанши мужийн Байнгын хорооны гишүүн асан Зао Зиёон /Zhao Zhiyong/-г хууль тогтоомж болон сахилгын зөрчилтэй холбоотойгоор албан тушаалаас нь буулгасан талаар мэдэгдэв. Тэрээр Жанши муж дахь дэд-сайдын түвшний 3 дахь албан тушаалтан байсан бөгөөд түүнийг намын сахилгын асуудлыг зөрчсөн хэрэгт буруутган мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлээд байна.</p> <p>(2) 6 дугаар сарын 5-ны өдөр Бээжин хотын дээд шүүхийн хоёр дахь шатны шүүх хурлаас Сангийн яамны Аж ахуйн нэгжийн газрын Нэгдсэн хэлтсийн дарга асан Чен Зубин /Chen Zhubing/-г хээл хахуулийн хэрэгт буруутай болохыг тогтоов. Анхан шатны шүүх хурлаас түүнийг хээл хахууль авсан хэрэгт буруутган бүх насаар нь хорих болон хувийн хөрөнгийг нь хураах шийдвэр гаргаж байсан юм.</p> <p>(3) Шаньси мужийн дээд шүүхээс Орон сууцны сангийн удирдах төвийн нарийн бичиг бөгөөд дарга асан Сюи Хуфэн /Xue Huaifeng/-д 6 дугаар сарын 18-ны өдөр 11 жилийн хорих ял ногдуулсан байна.</p> <p>(4) Хятадын төрийн өмчит, усан онгоц үйлдвэрлэгч "China Ocean Shipping Group Co., Ltd. ("COSCO")"-ийн Ерөнхий менежерийн орлогч асан Си Минжи /Xu Minjie/-г албан тушаалаа урвуулан ашигласан, төсвийн хөрөнгө завшсан хэрэгт буруутган Коммунист намаас хөөв.</p> <p>(5) Авлигын хэрэгт холбогдоод байгаа, Хятадын Армийн хорооны дэд ерөнхийлөгч асан Си Кайхоу /Xu Caihou/-г 6 дугаар сарын 30-ны өдөр Коммунист намаас хөөв. Түүнийг намаас хөөх шийдвэрийг тус улсын дарга Ши Зиньпиний зохион байгуулсан Коммунист намын Улс төрийн товчооны зөвлөгөөний үеэр гаргасан байна. Си Кайхоу нь өөрөө болон гэр бүлийн гишүүдээрээ дамжуулан хээл хахууль авсан хэрэгт буруутгагдаж байгаа бөгөөд 3 дугаар сарын 15-наас хойш шалгагдаж байгаа юм.</p>
Бусад арга хэмжээ:	<p>2014 оны 6 дугаар сарын 20-нд Хятадын Үндэсний аудитын газраас төрийн өмчийн 11 том аж ахуйн нэгжийн 2012 оны санхүүгийн орлого, зарлагын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын үр дүнгийн тайланг танилцуулав.</p> <p>Тус тайланд дурдсанаар дээрх аж ахуйн нэгжүүдийн дүнд авлигын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлүүд цөөнгүй байжээ. Тухайлбал, тансаг машин худалдан авах, ажилчдад хууль бус хөнгөлөлт үзүүлэх зэрэг олон тооны зөрчлүүд байв. Эдгээр 11 аж</p>

	ахуйн нэгжийн 190 албан хаагчид авлигын эсрэг хууль зөрчсөн хэмээн шийтгэл ногдуулсан байна. Мөн эдгээр аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны алдаагаа засах талаарх шаардлагыг хэрэгжүүлэхийг үүрэг болгосон аж.
2014 оны 5 дугаар сард	
1. Хууль тогтоомжийн хүрээнд	-
2. Шинэ болон шинэчлэн боловсруулахаар зорьж буй хууль тогтоомж	-
3. Засгийн газраас авлигын гэмт хэрэгтэй тэмцэхээр хэрэгжүүлж буй томоохон үйл ажиллагаа	(1) Ляонин мужийн Дандон хотын Иргэний агаарын хамгаалалын газрын гурван ажилтанг хээл хахууль авсан, албан үүргээ урвуулан ашигласан хэрэгт буруутган 4-13 жилийн хорих ял ногдуулсныг 5 дугаар сарын 13-нд мэдэгдлээ.
	(2) БНХАУ-ын Ардын прокурорын дээд газраас Үндэсний эрчим хүчний байгууллагын дэд дарга асан Си Юоншэнь /Xu Yongsheng/, Сэргээгдэх эрчим хүч, шинэ эрчмийн дарга асан Ван Жун /Wang Jun/ нарыг хээл хахууль авсан хэрэгт сэжиглэн, мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлснийг 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр цахим хуудсаараа дамжуулан мэдэгдлээ.
	(3) "Guangxi Yugang Expressway Co., Ltd"-ийн захирал асан Лу Моухай /Lu Mouhai/-г шүүхээс 5 дугаар сарын 28-ны өдөр авлигын хэрэгт буруутган 13 жилийн хорих ял ногдуулахын зэрэгцээ түүний 1 сая юаньтай тэнцэх хэмжээний хөрөнгийг хураан авах шийдвэр гаргасан байна.
Бусад арга хэмжээ:	(1) 2014 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Хятадын ардын дээд прокурорын газраас хэвлэлийн бага хурал зохион байгууллаа. Уг хэвлэлийн бага хурлын мэдээлэлд дурдсанаар 2014 оны эхний улиралд үндэсний хэмжээнд прокурорын байгууллагуудад авлига, хээл хахуулийн холбоотой 10840 хүн холбогдсон 8222 хэргийг шалгасан байна.

---оОо---